



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар  
сарын 11 өдөр

Дугаар 6-59

Улаанбаатар  
хот

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
дүрэм батлах, ажлаас чөлөөлөх,  
томилох тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Өөр ажилд шилжих болсонтой нь холбогдуулан н.Буян-Өлзийг 1997 оны 03 дугаар сарын 12-наар тасалбар болгон нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлж, Засаг даргын Тамгын газрын мэдэлд шилжүүлсүгэй.

3. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар Ендонгийн Тэрбишийг 1997 оны 03 дугаар сарын 12-ноос томилж, сарын үндсэн цалинг 32400 төгрөгөөр, нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар бодож тогтоосугай.

4. Албан хаагчдыг томилж, цалин нэмэгдлийг холбогдох журмын дагуу тогтоож ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (н.Тэрбиш) -т даалгасугай.

5. Эрүүл мэндийн газрын даргын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга	Ц.Болдсайхан	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүн	Х.Самбаа	-Тамгын газрын боловсон хүчний эрхлэгч
	Д.Хадхүү	-Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

*Ц. Наранцацралт* Ж НАРАНЦАЦРАЛТ



**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл:

- 1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар нь Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газар, нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх орон нутгийн төрийн захиргааны байгууллага (хэрэгжүүлэх агентлаг) мөн.
- 1.2. Эрүүл мэндийн газрын үндсэн зорилт нь нийслэлийн хүн амыг элдэв өвчнөөс анагаах ухааны аргаар урьдчилан сэргийлэх, эмчлэн сувилж, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулж, эм эмнэлгийн хэрэгслэлээр хангах, нийслэлд байгаа өмчийн олон хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын (эмнэлэг, сувилал, эрүүл ахуй, халдвар судлал, сувилалын яслы, эрүүл мэндийн төв, эм хангамж, үйлдвэр үйлчилгээний ) ажлыг уялдуулан зохицуулж, хүн амын эрүүл мэнд, эрүүлийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн байдалд дүгнэлт хийж ажиллах, нийслэлчүүдийг эрүүл ажиллаж, амьдарч, өсч хөгжих нөхцлийг бүрдүүлэх явдал мөн.
- 1.3. Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа "Монгол улсын Үндсэн хууль" болон "Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хууль" бусад хууль тогтоомж, Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, нийслэлийн Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг удирдлага болгоно.
- 1.4. Газар нь нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газрын харъяанд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.
- 1.5. Эрүүл мэндийн газар нь үндсэн үүрэг зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг оновчтой шийдвэрлэхэд зөвлөн туслах үүрэг бүхий (орон тооны бус) зөвлөлтэй байж болно.
- 1.6. Эрүүл мэндийн газрын дарга эрх хэмжээний асуудлаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, дүрэм заавар батлан, биелэлтийг нь зохион байгуулж хангуулна.
- 1.7. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, нийслэлийн Засаг даргаас гаргасан эрүүл мэндийн холбогдолтой тушаал, захирамж, дүрэм, зааврыг нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгууллага бүх хэвшлийн аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, албан тушаалтан, иргэдэд сурталчлан хэрэгжилт, үр дүнг шалган зааварчилна.
- 1.8. Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо, зохион байгуулалтыг нийслэлийн Засаг дарга тогтоож даргыг нь томилж чөлөөлнө.
- 1.9. Эрүүл мэндийн газар нь тэмдэг бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.



Хоёр. Эрүүл мэндийн газрын үүрэг:

2.1. Нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг гаргах.

2.2. Нийслэлийн аж ахуйн нэгж, олон нийт, засаг захиргааны байгууллагаас ажиллагсдынхаа эрүүл мэндийг хамгаалах, ажиллах, амьдрах нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй сайжруулах ажилд зөвлөн туслах,

2.3. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нийгэм, эдийн засаг, орчны нөлөө хүчин зүйлсийг судлан тогтоож, холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, шаардлагатай зарим асуудлаар хөтөлбөр боловсруулж, биелэлтийг нь хангуулах,

2.4. Нийслэл хотын дэвсгэр нутагт байгаа улс, хоршоолол, хувийн эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, эм хангамж, сувилалын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх, материаллаг баазыг бэхжүүлэх, үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах асуудлыг санаачлан эрх хэмжээнийхээ дотор шийдвэрлэх, холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх,

2.5. Улаанбаатар хотын хэмжээнд эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслэл багаж тоног төхөөрөмжийн хэрэгцээг судлан нэгтгэж, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, нийслэлийн Засаг даргын зөвлөлд оруулж шийдвэр гаргуулан, бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулах.

2.6. Анагаах ухааныг хөгжүүлэх, эрүүл мэнд, эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлалын тусламж, эм эмнэлгийн барааны үйлдвэрлэлд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, салбарын боловсон хүчний захиалгаар бэлтгүүлэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, хүн эмчлэх эрхийг баталгаажуулах,

2.7. Нийслэлийн хүн амын эрүүл мэнд, нийслэл дэх олон хэв шинжит эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, боловсон хүчин, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээг авч, сар, улирал, жилээр нэгтгэн дүгнэлт гарган нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, Засгийн газрын агентлагуудад мэдээлэх,

2.8. Хотын хүн ам зүйн холбогдолтой мэдээлэл хүлээн авч нэгтгэн дүгнэлт хийх,

2.9. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа хийж бие бялдар чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх,

2.10. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын аппаратын эмч, эм зүйч, ажилчдыг үр бүтээлтэй ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал тавих.

2.11. Нийслэл хотын хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эм биобэлдмэл, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдаалах, боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах асуудлаар гадаад улс орны болон нийслэл хотын хамтын ажиллагаатай хотуудын эрх тэгш байгууллагуудтай бие даан хамтран ажиллах,

Хууль тогтоомжоор олгогдсон эрхийн дагуу онош, эмчилгээний аппарат, тоног төхөөрөмжийг нэг байгууллагаас нөгөөд нь шилжүүлэн хуваарилж, зохицуулах,

Гурав. Эрүүл мэндийн газрын эрх:

3.1. Хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон асуудлаар нийслэлийн дэвсгэрт байгаа аж ахуй, олон нийтийн болон төр захиргааны байгууллагын ажлыг шалгаж зөвлөх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

3.2. Нийслэлийн иргэдийн эрүүл мэндийн асуудлаар холбогдол бүхий байгууллага иргэдээс мэдээ, мэдээллийг гаргуулж авах.

3.3. Нийслэл Улаанбаатар хот дахь эрүүл мэндийн нэгж байгууллагыг байгуулах, өргөтгөн өөрчлөх, татан буулгах асуудлыг хамт олон хөдөлмөрчдийн санал, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яаманд тавьж шийдвэрлүүлэх.

3.4. Эрүүл мэндийн харъяа байгууллагын захирал, дарга, ерөнхий эмчийг ажилд томилох ба өөрчлөх асуудлыг нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлүүлэх.

3.5. Эрүүл мэнд, эмнэлэг, эмийн тусламж үзүүлэх зөвшөөрлийг хоршоо, гүүс, хувь хүнд олгох, үйл ажиллагаанд нь мэргэжлийн хяналт тавих, ажиллагааг нь зогсоох,

3.6. Нийслэл дэхь эрүүл мэндийн байгууллагыг эмч, хөрөнгө, санхүү, төсвийн үйл ажиллагааны зарцуулалтад хяналт тавих, шалгах, илэрсэн зөрчлийг хууль зүйн дагуу арилгуулах.

3.7. Хууль зүйд нийцээгүй элдэв зөрчил дутагдлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, ажиллагсдын нэр төр эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн асуудал боловсруулж тавих.

3.8. Эмч, эмнэлгийн ажилчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, туршлага судлуулах зорилгоор гадаад орнуудаас өндөр мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах.

3.9. Нийслэл дэхь олон хэв шинжит эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээний чанар, эм биобэлдмэлд улсын хяналт хийж, зөрчлийг арилгуулах, хууль зүйд нийцүүлэн хариуцлага хүлээлгэх.

3.10. Тэргүүний ажиллагаатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг өөрийн эрхийн хэмжээнд шагнаж, урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох.